



ХУРЛЫН ХУРАЛДААН:

Увс аймгийн ИТХ-ын 7 дахь удаагийн сонгуулийн Анхдугаар хуралдаан хуралдлаа.



Увс аймгийн ИТХ-ын 7 дахь удаагийн сонгуулийн Анхдугаар хуралдаан 2016-07-14-ны өдөр хуралдаж 4 асуудал хэлэлцэн шийдвэрлэв. Үүнд:

Төлөөлөгчдийн бүрэн эрхийг батлах

Аймгийн ИТХ-ын даргыг сонгож томилох

Аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийг сонгож томилох

Аймгийн Засаг даргад нэр дэвшигчийг сонгож батлан МУ-ын Ерөнхий сайдад уламжлах

40 төлөөлөгчийн бүрэн эрхийг баталлаа.

Аймгийн Сонгуулийн хорооноос сонгуулийн үр дүнг танилцуулан мэдээлэл хийж 41 төлөөлөгчийн бүрэн эрхийг батлуулахаар тогтоолын төсөл өргөн барьсан боловч хуралдааны үед Өмнөговь сумын 10-р тойрогт нэр дэвшиж өрсөлдсөн Нямбаяр нь сонгуулийн хууль зөрчсөн тухай маргаан хууль хяналтын байгууллагад шалгагдаж байгаа гэдэг үндэслэлээр шүүхээр эцэслэн шийдвэрлэгдэх хүртэл бүрэн эрхийг нь батлахаас татгалзсан шийдвэр гаргав. Ингээд 40 төлөөлөгчийн бүрэн эрхийг баталж төлөөлөгчийн үнэмлэх, энгэрийн тэмдэг гардуулав

Монгол Ардын Намын 35, Ардчилсан Намын 4, бие даагч 1 төлөөлөгчийн бүрэн эрхийг баталгаажууллаа.

Аймгийн ИТХ-ын даргаар Э.Насанбатыг сонгож батлав.

Анхдугаар хуралдаан 97,6 хувийн ирцтэй хуралдаж, хуралдааныг хамгийн ахмад настай төлөөлөгч болох Баруунтуруун сумаас сонгогдсон С.Лхагвасүрэн удирдан явуулсан. Аймгийн ИТХ-ын даргад Сагил сумаас нэр дэвшин аймгийн ИТХ-д сонгогдсон Эвэлсүрэнгийн Насанбатыг нэр дэвшүүлж хуралдаанд оролцсон 40 төлөөлөгчийн 100 хувийн саналаар Увс аймгийн ИТХ-ын даргаар сонгосон юм.

Аймгийн ИТХ-ын 11 тэргүүлэгчийг сонгож батлав.

Аймгийн ИТХ-ын тэргүүлэгч 11 хүний бүрэлдэхүүнтэй ажиллахаар болж тэргүүлэгчээр 13-н хүн нэр дэвшиж, нууцаар санал хураалт явуулахад Э.Насанбат, Э.Баатарсан, Д.Мягмарсүрэн, Ю.Төгсжаргал, М.Мөнхөө, Г.Цэрэндулам, Л.Арцанхүү, А.Хилэнбаатар, Б.Сүх-Очир, Е.Баяраа, С.Анхбаяр нар хамгийн олон хүний санал авч аймгийн ИТХ-ын тэргүүлэгчээр сонгогдлоо. Тэргүүлэгчдэд МАН-аас 9, АН-аас 1, бие даагч 1 төлөөлөгч сонгогдов.

Аймгийн Засаг даргад Д.Батсайханыг томилохоор нэр дэвшүүлэн баталж МУ-ын ерөнхий сайдад уламжлав.

Аймгийн Засаг даргад МАН-ын бүлгээс аймгийн МАН-ын дарга Д.Батсайхан, хуралдааны танхимаас Ю.Төгсжаргал нарыг нэр дэвшүүлэв. Нэр дэвшигчдээс саналыг нь сонсох үед Ю.Төгсжаргал нэрээ татаж санал хураахад төлөөлөгчдийн 90 хувийн саналаар Д.Батсайханыг дэмжиж Увс аймгийн Засаг даргаар томилуулахаар Монгол Улсын Ерөнхий сайдад өргөн мэдүүлээ.

ТЭРГҮҮЛЭГЧИЙН ХУРАЛ:

1. 07-р сарын 04-ны өдрийн аймгийн ИТХ-ын тэргүүлэгчид хурлаар дараах 4-н асуудлыг хэлэлцэн шийдвэрлэлээ. Үүнд: Хуралдааны тов зарлах тухай - Ч.Чимэд, ИТХ-ын дарга, Б.Ядамсүрэн, Сонгуулийн хорооны гишүүн

Ой тэмдэглэх тухай - Б.Ядамсүрэн, НХХ-ын дарга

ОНӨмчийн тухай - Р.Соёлмаа, ИТХ-ын ажлын албаны мэргэжилтэн
Шагналд тодорхойлох тухай- А.Ариунтуяа, ТЗУХ-ийн мэргэжилтэн.



2. 07-р сарын 16-ны өдрийн аймгийн ИТХ-ын

Тэргүүлэгчдийн хурлаар дараах 3-н асуудлыг хэлэлцэн шийдвэрлэлээ. Тэтгэмж олгох, ээлжийн амралтын тооцоо хийх тухай - Э.Насанбат, Аймгийн ИТХ-ын дарга

Аймгийн Засаг даргын орлогчийн тухай - Д.Батсайхан, Аймгийн Засаг дарга

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргыг чөлөөлж, томилох тухай - Э.Насанбат, Аймгийн ИТХ-ын дарга

Аймгийн Засаг даргын орлогчийн тухай - Д.Батсайхан, Аймгийн Засаг дарга

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргыг чөлөөлж, томилох тухай - Э.Насанбат, Аймгийн ИТХ-ын дарга

ТӨРИЙН ДЭЭД ОДОН, МЕДАЛЬ ГАРДУУЛЛАА.



Тулгар төрийн 2225, Их Монгол улс байгуулагдсаны 810, Үндэсний их баяр наадам, Ардын хувьсгалын 95 жилийн ойг тохиолдуулан Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2016 оны 07-р сарын 07-ны 89-р зарлигаар эрхэлсэн салбартаа олон жил үр бүтээлтэй ажилласан иргэдийг төрийн дээд одон, медалиар шагнасан.

Шагналыг өнөөдөр аймаг, орон нутгийн удирдлагууд “Галдан бошгот” хааны хүндэтгэлийн өргөөнд ёслол төгөлдөр гардуулан өгч, баяр хүргэлээ.

Ийнхүү эрхэлсэн салбартаа олон жил үр бүтээлтэй хөдөлмөрлөн улс, аймаг, орон нутгийнхаа хөгжил цэцэглэлт бүтээн байгуулалтын их үйлсэд өөрийн авъяас чадвар, оюун ухаанаа зориулсан 42 иргэн үндэсний их баяр наадмын өдөр төр засагтаа хөдөлмөрөө үнэлүүлэн гавъяа шагналаа гардан авлаа.



УВС АЙМГИЙН БАЯР НААДАМ САЙХАН БОЛЖ ӨНГӨРЛӨӨ.

Ардын хувьсгалын 95 жил, Увс аймаг байгуулагдсаны түүхт 91 жилийн ойн баяр наадам 2016.07.18,19-ний өдрүүдэд амжилттай зохион байгуулагдлаа. Наадмын үеэр өөрийн ажиллаж буй салбартаа амжилт гаргасан хүмүүсийг төрийн дээд одон медалиудаар шагнаж урамшуулсан бөгөөд наадмын хүрээнд зохион байгуулагдсан тэмцээн уралдаанд амжилттай оролцож тэргүүн байр эзэлсэн баг тамирчдыг шагнаж урамшууллаа.



Жил бүрийн наадмаар 60-аас дээш насны аймаг, улсын цолтой бөхчүүдэд гарын бэлэг гардуулдаг уламжлалын дагуу бөхчүүддээ хүндэтгэл үзүүллээ. Улс, аймаг, сумын



цолтой 256 бөх зодоглосноос Увс аймгийн Өндөрхангай сумын харъяат Аймгийн харцага Д.Тогтохжаргал түрүүлж Аймгийн арслан цол, Увс аймгийн Тэс сумын харъяат сумын заан Ж.Ням-Эрдэнэ үзүүрлэж аймгийн заан цол хүртсэн бол Увс аймгийн Зүүнговь сумын харъяат

Аймгийн начин Т.Хайдав их шөвөгт шалгарч аймгийн харцага цол, Увс аймгийн Давст сумын харъяат Э.Лхамхүү, С.Жамсран,



Увс аймгийн Өмнөговь сумын харъяат Б.Алтангэрэл нар 5 давж аймгийн начин цол тус тус хүртлээ. Ардын хувьсгалын 95 жил, Увс аймаг байгуулагдсаны түүхт 91 жилийн ойн баяр наадмын хурдан морьдын уралдаан ямар нэгэн маргаан будлиангүй болж өндөрлөлөө.

ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГА ҮҮСЧ ХӨГЖСӨНИЙ 95-ЖИЛИЙН ОЙ ТОХИОЖ ТОХИОЛОО.

Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 202 дугаар тогтоолын дагуу жил бүрийн долдугаар сарын 19-ний өдөр Цагдаагийн болон Дотоодын цэргийн алба хаагчдын өдрийг тэмдэглэж байхаар тогтсон байдаг.



Өнөөдөр Маршал Ю.Цэдэнбалын талбайд Увс аймаг дахь цагдаагийн газраас цагдаагийн байгууллага үүсч хөгжсөний 95 жилийн ойн нээлтийн үйл ажиллагааг зохион байгууллаа.

Нээлтийн үйл ажиллагаанд аймгийн ИТХ-ын дарга Э.Насанбат, Засаг дарга Д.Батсайхан нар оролцож цагдаагийн албан хаагчдад ойн баярын мэндчилгээ дэвшүүлж, ажил үйлсээрээ бусдыгаа манлайлсан зарим албан хаагчдад аймгийн хүндэт тэмдэг, аймгийн ИТХ-ын “Баярын бичиг”, аймгийн Засаг даргын “Жуух бичиг”, “Өргөмжлөл” гардууллаа.

1921 онд ардын хувьсгал ялсны дараахан ардын засгийн газрын шийдвэрээр “Сэргийлэх цэрэг” нэртэйгээр байгуулагдан түүхэн цаг үеүдийг өртөөлсөөр 95 жилийн ойттойгоо ийнхүү золголоо.

Аливаа салбарын алба хаагчдын тэмдэглэлт өдрийг тэмдэглэх нь тухайн салбарын ололт амжилтыг олон нийтэд мэдээлж сурталчлах, түгээн дэлгэрүүлэх, харилцан туршлага солилцох, иргэдэд үйлчилгээ үзүүлэх, тэдний санал хүсэлтийг сонсож, бүтээлч ажил, үйл ажиллагаанд оролцуулах алба хаагчдын хөдөлмөр бүтээл, алдар гавьяаг алдаршуулах зорилго агуулж байдаг билээ.

АЙМГИЙН СОНГУУЛИЙН ХОРОО БАЙГУУЛАГДЛАА.

Аймгийн ИТХ-ын тэргүүлэгчид 2016 оны 07-р сарын 29-ний өдөр хуралдаж аймгийн сонгуулийн хороог дараах бүрэлдэхүүнтэй байгууллаа.

Аймгийн Сонгуулийн хорооны дарга Батбаатарын Эрдэнэсүрэн /Аймгийн ЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга/

Нарийн бичгийн дарга Цэнцэнгийн Баттулга /Аймгийн Мэргэжлийн хяналтын газрын улсын байцаагч/

Гишүүд Бадаагийн Бүрнээхүү /Аймгийн цогцолбор 2-р сургуулийн багш/

Намчингийн Энхжаргал /Аймгийн ИТХ-ын ажлын албаны ахлах мэргэжилтэн/

Раашын Отгонбаяр /УБСГ-ын Бүртгэлийн хэлтсийн улсын бүртгэгч/

Гантөмөрийн Галхүү /Улаангом сумын МЭҮТ-ийн менежер/

Жамъяансүрэнгийн Тувшинтөгс /Аймгийн цогцолбор 1-р сургуулийн багш/

Хаяг

Увс аймаг, Улаангом хот, 3-р баг
Ө.Бадрахын гудамж,
ЗДТГ-ын байр 210тоот

Утас :70453627

Факс :70452214

И Мэйл:

info@khural.uv.gov.mn

Вэб сайт:

http://uvs.khural.mn/

Facebook:

Увс аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал